



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/55

Арвайхээр

### Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8 дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2020 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, 10 дугаар зарлиг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2018 оны “Журам батлах тухай” А/274 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс мөн оны 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан 24 цагийн хүнсний дэлгүүрийг бусад хүнсний дэлгүүрийн адил 21 цаг хүртэл ажиллуулах, эмийн сангуудыг хуваарь гарган 24 цагаар ажиллуулах, архи согтууруулах ундааг 18 цагаас хойш худалдаалахгүй байх, баар, караоке, цэнгээний газруудын үйл ажиллагааг түр зогсоох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсүгэй.

3. Банк, худалдаа, үйлчилгээний газруудад амны хаалт зүүгээгүй иргэдэд үйлчлэхгүй байх, үйлчилсэн тохиолдолд үйл ажиллагааг нь даруй зогсоох арга хэмжээ авч ажиллах, төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээний газруудад ариутгал халдваргүйтлийг тогтмол хийлгэж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Цагдаагийн газар (О.Ганбат), сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Шашны байгууллагуудын шашин номын хурал, цуглаан, зан үйлд иргэд, олон нийтийг оролцуулахгүй байх, эм, эмнэлгийн хэрэгсэл, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосонтой холбогдуулан багш нарт 03 дугаар сарын 02-ны өдөр хүртэл цалинтай чөлөө олгож, амрахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т даалгасугай.

011100121

6. Цагаан сарыг өргөнөөр тэмдэглэхгүй, хот, аймаг, сум дамжин золголт хийхгүй байхыг олон нийтэд өргөн далайцтай сурталчлах ажлыг зохион байгуулахыг хэвлэл мэдээллийн нэгдсэн холбооны дарга (Т.Чимэддорж), аж ахуй нэгж, байгууллагын удирдлага, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7. Хот хоорондын болон орон нутгийн зорчигч тээврийн хэрэгсэлд ариутгал, халдваргүйтгэл хийх, зорчигчдод хяналт тавихыг Автотээврийн төв (З.Балданням), сумын Засаг дарга нарт даалгасугай.

8. Шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т даалгасугай.

9. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам"-ыг хэрэгжүүлж ажиллахыг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

10. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД